

ТОЙМ



**ОЛОН УЛСЫН
ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ**

2024.06.24

Голомт Капитал ҮЦК-д бэлтгэв

Хувьцааны зах зээлийн онцлох мэдээ

ТОВЧ

- Nvidia дэлхийн хамгийн том зах зээлийн үнэлгээтэй компани боллоо.
- Долоо хоногийн төгсгөлд зах зээл уналтыг үзүүллээ.
- Аж үйлдвэрийн үйлдвэрлэл 0.9 хувиар өссөн нь сүүлийн жил гаруй хугацаанд байгаагүй хурдацтай өсөлт болоод байгаа ч хэрэглэгчдийн эрэлт байна.
- Хятадад шинэ орон сууцны үнэ тавдугаар сард 0.7%-иар буурсан нь өнгөрсөн 10 гаруй жилийн хугацаанд болсон хамгийн хүчтэй бууралт боллоо.
- Ажилгүйдлийн түвшин 5%-ийн түвшинд тогтвортой хэвээр хадгалагдаж байна.
- Хятадын Ардын Банк банкнуудад 182 тэрбум юанийн санхүүжилт олгохоор болоод байна.

2024 он 6-р сарын 24

Dow Jones	39,150.33
S&P 500	5,464.62
Nasdaq	17,693.38
DAX	18,185.23
FTSE 100	8,237.72
S&P/ASX 200	7,796.00
HANG SENG	18,053.96

АНУ-ын индексийн өгөөж

Индекс	Өдрийн	Долоо хоног	Сар	Жилийн эхнээс	Жил	3 жил
Dow Jones	0.04%	0.96%	0.21%	3.88%	16.08%	13.70%
S&P 500	-0.16%	-0.16%	3.01%	14.57%	25.67%	27.66%
Nasdaq	-0.16%	-0.92%	4.57%	17.87%	31.13%	23.21%

2024 оны 6 сарын 24-ны 14:30



Европын индексийн өгөөж

Индекс	Өдрийн	Долоо хоног	Сар	Жилийн эхнээс	Жил	3 жил
DAX	-0.38%	0.65%	-2.72%	8.56%	14.88%	16.51%
FTSE 100	-0.42%	1.17%	-0.96%	6.52%	10.40%	15.44%

2024 оны 6 сарын 24-ны 14:30



Ази Номхон далайн индексийн өгөөж

Индекс	Өдрийн	Долоо хоног	Сар	Жилийн эхнээс	Жил	3 жил
S&P/ASX 200	-0.80%	0.43%	0.08%	1.88%	8.94%	5.83%
Hang Seng	-0.85%	-0.20%	-3.80%	5.01%	-5.24%	-38.88%

2024 оны 6 сарын 24-ны 14:30





Хувьцааны зах зээлийн онцлох мэдээ

Голлох индексүүд дахин бүх цаг үеийн дээд ханшаа дахин эвдлээ.

S&P 500 болон NASDAQ 100 индексийн хувьд бүх цаг үеийн дээд ханшаа дахин шинэчлэн тогтоогоод байгаа ба лхагва гарагт Juneteenth буюу Үндэсний тусгаар тогтнолын өдөр тохиож зах зээл хаалттай байлаа. Долоо хоногийн дундуур индексүүд өсөлтийг үзүүлсэн ч пүрэв гарагаас зах зээл бага зэргийн уналтыг үзүүлэн хаагдаад байна. Энэ нь мэдээж голлох нөлөөг үзүүлдэг технологийн компаниудын хувьцаа долоо хоногийн сүүлээр уналттай байсантай холбоотой.

NVIDIA дэлхийн хамгийн том зах зээлийн үнэлгээтэй компани боллоо.

Тус компани нь энэ сарын эхээр зах зээлийн үнэлгээгээр Apple компанийг гүйцэж байсан бол 1 өдрийн дотор 3.51 хувийн өсөлтийг үзүүлэн Microsoft компанийг давснаар дэлхийн хамгийн том компани болон бичигдлээ. Nvidia компани 2 их наядаас 3 их наяд ам.долларын босгыг давахад ердөө 96 өдрийг зарцуулсан ба Microsoft 945, Apple 1044 өдрийг тус бүр зарцуулж байжээ. 140 ам.долларын шинэ үнийг тогтоогоод байсан Nvidia долоо хоногийн төгсгөлд 2.35 хувийн уналтыг үзүүлэн хаагдаад байна.

Үйлдвэрүүд сайн ажиллаж байгаа ч хэрэглэгчдийн эрэлт бага байна.

Баасан гаригт индекс, хувьцаа болон ETF-үүдийн 5.5 их наяд ам.долларын опционы хугацаа дуусах дөхсөнийг мэдээлсэн байна. Жижиглэнгийн худалдааны борлуулалт 5-р сард ердөө 0.1 хувиар өссөн ба 4-р сард 0.2 хувиар буураад байсан юм. Харин хоолны газар болон цэнгээний газруудын борлуулалт эрчимтэй буурч байгаа бөгөөд энэ нь иргэдийн илүү зүйлд зарцуулах мөнгө багассаныг илтгэж байна.

Аж үйлдвэрлэлийн гарц 5-р сард 0.9 хувиар өссөн нь сүүлийн жил гаруй хугацаанд байгаагүй хурдацтай өсөлттэй байгааг Холбооны Нөөцийн Сан мэдэгдэв. S&P 500 Global -аас гаргадаг аж үйлдвэрлэлийн PMI индексийн 6-р сарын урьдчилсан мэдээгээр 54.6 болж өссөн нь сүүлийн 2 гаруй жилийн хугацаанд байгаагүй өсөлт байлаа. Үүний зэрэгцээ үйлчилгээний салбарын орлого тогтвортой байгаа ба нөгөө талд тус салбарын цалингийн дундаж дүн өсөөд байна.

График 1: АНУ-ын S&P500 индексийн ханшийн таамаглал

abiltgoun published on TradingView.com, Jun 24, 2024 14:52 UTC+8

S&P 500 Index, 1D, OANDA (C5,481.0 (C5,483.6 (C5,464.6 (C5,479.4 -1.6 (-0.03%)



TradingView



Хувьцааны зах зээлийн онцлох мэдээ

Аж үйлдвэрийн салбарын гарцын өсөлт 5.6%-д хүрч буурлаа

Аж үйлдвэрийн гарц тавдугаар сард өнгөрсөн оны үеэс 5.6%-иар өссөн нь хүлээлтээс бага гарсан бөгөөд энэ нь дөрөвдүгээр сарын 6.7%-ийн өсөлтөөс удааширсан үзүүлэлт юм. Үндсэн хөрөнгийн хөрөнгө оруулалт жилийн эхнээс тавдугаар сар хүртэл 4%-иар өссөн ч, нэгдүгээр сараас дөрөвдүгээр сар хүртэлх үзүүлэлтээс муу гарсан нь үл хөдлөх хөрөнгийн хөрөнгө оруулалт багассантай холбоотой. Харин жижиглэн худалдааны борлуулалт тавдугаар сард өнгөрсөн оны үеэс 3.7%-иар өссөн нь хүлээлтийг давсан бөгөөд дөрөвдүгээр сарын 2.3%-ийн өсөлтийг давсан байна. Харин улс даяарх хотын ажилгүйдлийн түвшин 5%-ийн түвшинд тогтвортой хадгалагдаж байна.

Хятадын Ардын Банк банкнуудад 182 тэрбум юанийн санхүүжилт олголоо

Хятадын Ардын Банк дунд хугацааны зээл олгосноор банкуудыг 182 тэрбум юанийн хөрвөх чадвараар хангаж зээлийн хүүг хүлээлтийн дагуу 2.5%-д хэвээр үлдээв. Энэ сард 237 тэрбум юанийн зээлийн төлөлтийн хугацаа дуусаж байгаатай холбогдуулан банкууд төлөлтөнд нь 55 тэрбум юанийн хөрөнгийг зарцуулсан бөгөөд нэмэлтээр төв банк богино хугацааны зээлээр олгосноор 4 тэрбум юань нэмэлт санхүүжилтаар хангажээ. Хятадын банкууд нэг жилийн болон таван жилийн зээлийн жишиг хүүг хүлээлтийн дагуу 3.45% болон 3.95%-д тус тус хэвээр үлдээв.

Шинэ орон сууцны үнэ 0.7% буурсан нь орон сууцны зах зээл хүндрэлтэй хэвээр буйг илтгэж байна

БНХАУ-ын Үндэсний Статистикийн Хорооны мэдээлснээр шинэ орон сууцны үнэ тавдугаар сард 0.7%-иар буурсан нь дөрөвдүгээр сарын үзүүлэлт буюу 0.6%-ийг давсан үзүүлэлт бөгөөд өнгөрсөн 10 гаруй жилийн турш болсон хамгийн огцом бууралт юм. БНХАУ-ын Засгийн газар тавдугаар сард үл хөдлөх хөрөнгийн салбарыг сэргээхэд зориулагдсан дэмжлэгийн багцыг танилцуулсны дараа шинэ орон сууцны ханш өмнөх 10 сарын адилаар буурсан үзүүлэлттэй гарсан байна. Зарим шинжээчид эдгээр арга хэмжээ нь орон сууцны зах зээлийн уналтыг зогсооход хангалтгүй байж магадгүйг анхааруулж байна.

График 2: Hang-Seng индексийн ханшийн таамаг

abiltuun published on TradingView.com, Jun 24, 2024 14:53 UTC+8

Hang Seng Index Futures, 1D, HKEX O18,017 H18,057 L17,778 C17,880 -138 (-0.77%)



ТАЙЛАНГИЙН ХУАНЛИ

Хүснэгт 1: Өнгөрсөн долоо хоногт тайлангаа зарласан компаниуд

E EARNINGS WHISPERS									
Most Anticipated Earnings Releases									
for the week beginning June 17, 2024									
Monday		Tuesday		Wednesday		Thursday		Friday	
Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close
	LENNAR	AMERICA'S CAR-MART	kb HOME	Steelcase		AURORA	Smith&Wesson	CARMAX	
	LA BOY	Cognyte				accenture	ALGOMA	FACTSET	
	Quantum	PATTERSON COMPANIES, INC.				Kroger			
						DARDEN RESTAURANTS			
						JABIL			
						WINNERBAGO			
						TEN LTD			
						GMS			
						SILVACO			
http://eps.sh/cal						© 2024 Earnings Whispers			

Хүснэгт 2: Энэ долоо хоногт тайлангаа зарлах компаниуд

E EARNINGS WHISPERS									
Most Anticipated Earnings Releases									
for the week beginning June 24, 2024									
Monday		Tuesday		Wednesday		Thursday		Friday	
Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close
MoneyHero	ENERPAC TOOL GROUP	CARNIVAL CORPORATION & P&L	FedEx	PAYCHEX	Micron	WBA	NKE		
Beyond Air		TD SYNnex	Progress	General Mills	BlackBerry	McCOMICK	Accolade		
		AIRSHIP	GREENTREE HOSPITALITY GROUP	UniFirst	Levi's	AcuityBrands	PINSTRIPES		
				DAKTRONICS	AeroVironment	SimplyGood	AMERICAN OUTDOOR BRANDS		
					CONCENTRIX	entopress inc.			
					H.B. Fuller	LINDSAY			
					MillerKnoll				
					Jefferies				
					FranklinCovey				
					CULP				
http://eps.sh/cal						© 2024 Earnings Whispers			